

даатгуулагчид илүү олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 0,9 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын санд нөхөн төлүүлэхээр, мөн нэр бүхий З иргэнд үндэслэлгүйгээр олгосон тэтгэмж 3,0 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын санд нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн 32/00040 дугаар акт,

Шалгалтын актаар тогтоогдсон төлбөрийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын талаарх тайланг 2024 оны 12 дугаар сарын 01-ний дотор Хяналт шалгалтын газарт ирүүлэх нь зүйтэй.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ:

Тус газар нь даатгуулагчдын хамрах хүрээг нэмэгдүүлэн, иргэд даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг цаг хугацаанд нь олгож үйлчилсэн, сангийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан, ажил олгогч, иргэд, даатгуулагчдад хөнгөн шуурхай үзүүлэх зорилгоор түншлэл хамтын ажиллагааг дэмжиж МОНПАС ХХК-н, НЫЮКОМПАСС ХХК-н тус тус хамтран аж ахуйн нэгж байгууллагад тоон гарын үсгийн төхөөрөмж, нэг жилийн эрхийг 2021 онд үнэгүй олгох ажлыг зохион байгуулж, тоон гарын үсгээр тайлан авч хэвшсэн боловч сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлээгүй, "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт"-ыг зөрчиж хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллаагүй иргэнд хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоосон, тэтгэврийг илүү дутуу тооцож, олгосон, аймгийн санхүүгийн хяналт, шалгалтаар төлбөр, зөрчил илэрсэн, дотоодын хяналт, шалгалтыг хангальгүй зохион байгуулсан, нийгмийн даатгалын газрын зүгээс сумдын байцаагч нарын үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулж, мэргэжил арга зүйн удирдлагаар болон зөвлөн туслах үйлчилгээг шаардлагын түвшин хийж ажиллаагүй байна.

Шалгалтын ерөнхий дүнгээс үзэхэд сангийн болон үйл ажиллагааны батлагдсан зардал, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, өмнөх шалгалтын мөрөөр тодорхой ажлуудын зохион байгуулж, хэрэгжүүлэн, үйл ажиллагаандaa ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэн ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулж ажилласан хэдий ч цаашид дотоодын хяналт шалгалтын ажлыг төлөвлөгөөний дагуу тогтмол хийж, ажлын ахиц дэвшил гарган идэвх санаачлагатай ажиллах шаардлагатай гэж дүгнэлээ.

ТАНИЛЦУУЛГА

БИЧСЭН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААЛЧ

Б.ЗУЛ

Б.БАТСУУРЬ

Хэнтий аймгийн НДГ-т хийсэн шалгалтын дүн

ТАНИЛЦСАН:

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗАР
ГАЗРЫН ДАРГА

Н.НЯМХАТАН
САНХҮҮ БҮРТГЭЛ, ХАМРАЛТ,
ОРЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

УЛСЫН БАЙЦААГЧ



А.СОЖИДМАА

Ж.ГАНЗОРИГ

А.ЭРДЭНЭЧИМЭГ

ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Н.ЦОЛМОНБАЯР

ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.ОКТЯБРЬ

**ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН НИЙТ ТӨЛБӨР,
ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**

№	Төлбөр зөрчлийн утга	Шалгалтанд хамрагдсан		Актын дугаар	Илүү, дутуу	Илэрсэн төлбөр, зөрчил	Төлүүлэхээр шийдвэрлэс эн нь
		Бай-н тоо	Хүний Тоо				
A	Б	1	2	3	4	5	6
	Тэтгэвэр тэтгэмжийн даатгалын сан						
1 Үүнээс	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт	1	5 12	32/00037	1 806 014 2 402 956	1 806 014 2 402 956	1 806 014 2 402 956
	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, ЦАХТТХуулийн 4 дүгээр зүйл Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/31 дүгээр тушаалаар баталсан "Тэтгэвэр тогтооход шаардах баримт бичгийг бүрдүүлэх журам"-ын 9.2 дахь хэсэг	1	5 10		47 015 603 29 121 542	47 015 603 29 121 542	47 015 603 29 121 542
	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт	1	1	32/00039	19 852 978	19 852 978	Зогсоох
	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны А/177, А/433 дугаар тушаалын хавсралт Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журамын 5 дугаар зүйлийн 5.6.3 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт	1	33	32/00040	11 732 717	11 732 717	11 732 717
Дүн		4	66		111 931 810	111 931 810	92 078 832

Хэнтий аймгийн НДГ-т хийсэн шалгалтын дүн